

Нийгмийн ажил, сэтгэл зүй**ХОРИХ АНГИАС СУЛЛАГДСАН ОРОН ГЭРГҮЙ ИРГЭДТЭЙ АЖИЛЛАХ
НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР, ЗАГВАРУУД****PROGRAMS GND MODELS OF SOCIAL WORK SERVICES FOR
WORKING WITH HOMELESS PEOPLE RELEASED FROM PRISON****Г.Батжаргал**

*Сургалт, судалгааны 403 дугаар анги-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн ахлах
багш, хошууч*

Хураангуй: Орон гэргүй иргэдийн асуудал нь хөгжингүй болон хөгжиж буй аль ч оронд өнөөдрийг хүртэл тулгамдсан, нийгмийн асуудлын нэг болсоор байна. Орон гэргүй иргэдийн талаар засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд хамтарч халамжийн бодлого, төсөл хөтөлбөр маш ихээр хэрэгжүүлдэг ч төдийлөн буурахгүй байгаа. Ихэнх орны хувьд орон гэргүй иргэд нь дотроо ангилалтай болж хүн ам зүйн тодорхой бүлгийн шинжтэй болж байна. Тухайлбал: орон гэргүй иргэд нь дотроо эрэгтэй, эмэгтэй, хүүхдүүд, ахмадууд, орон гэргүй гэр бүл гэх мэт. Орон гэргүй иргэдтэй ажиллах нийгмийн ажил нь макро орчин буюу нийгмийн бодлого, эрх зүйн орчинд, мезо буюу нийгмийн дэд систем, байгууллага, олон нийтийн орчинд, микро буюу гэр бүл, хувь хүний гэсэн гурван түвшинд хүргэх үлчилгээний загварыг энэхүү өгүүлэлд тусгалаа.

Түлхүүр үг: орон гэргүй хүн, нийгмийн ажил, халамж, хөтөлбөр, хорих ангиас суллагдсан иргэн

Abstract: The problem of homelessness remains one of the pressing social problems in both developed and developing countries. The government and civil society organizations jointly implement welfare policies and projects for homeless people, but it is not decreasing. In most countries, homeless people are classified within a specific demographic group. For example: homeless people include men, women, children, elders, homeless families, etc. This article reflects the simulation model of social work working with homeless people at three levels: macro environment or social policy and legal environment, meso or social subsystem, organization and community environment, micro or family and individual.

Key words: homeless person, social work, welfare, program, or citizen released from prison

Удиртгал

Манай улсад хийгдсэн хэд хэдэн судалгаанаас орон гэргүй хүмүүсийн тухай тодорхойлолтыг авч үзвэл "Гудамж, байрны орц, хонгилд амьдардаг хүн", "Гэрээсээ удаан хугацаагаар дайжин, нийтийн эзэмшлийн газар хоноглодог хүмүүс" гэх мэтээр судлаачид янз бүрээр тодорхойлдог. "Орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэн гэдэг нь бусдын хүчирхийлэл, бусдын дарамт, санаатай, санаандгүй үйлдэл болон өөрийн буруутай үйлдлийн улмаас байрны орц, хонгил, траншейнд сүүлийн 1 сар амьдарч байгаа тэжээн тэтгэх гэр бүл, төрөл садангүй эсвэл тэдгээр нь дэмжлэг туслалцаа үзүүлэхээс татгалзсан иргэнийг хэлнэ" гэж албан ёсоор тодорхойлсон.¹ Энэ тодорхойлолт нь Монгол улсын хэмжээнд орон гэргүй хүн гэдгийг ойлгох ойлголтыг илүү тодорхой болгож өгсөн.

Америкт орон гэргүй хүмүүсийг "Хоумлес (homeless)" гэж нэрлэдэг бөгөөд энэ тохиолдол нь үнэхээр орон гэргүй амьдардаг эсвэл хамгаалах байранд амьдардаг тохиолдлоор хязгаарлагдана. Орон гэргүй хүмүүсийг дэмжих хөтөлбөрийн тухай хууль болох "Орон гэргүй хүмүүсийн дэмжих хууль" (1987) батлагдаж Холбооны засгийн газрын тодорхойлолтоор "орон гэргүй хүн гэдэг нь тогтсон, хэвийн бөгөөд тохь тухтай унтах газаргүй хүн, мөн түр амьдрах газар болон олон нийтийн, хувийн хэвшлийн удирдан ажиллуулдаг хамгаалах байр (welfare hotel, transitional housing) эсвэл байгууламж, хаягдсан барилга, машин, цэцэрлэгт хүрээлэн, гудамж мэтийн унтах газарт тооцогдохгүй газрыг ашигладаг хүмүүсийг хэлнэ" гэж дурдсан байдаг. Энэ конгрессын тодорхойлолтоор бол өөрийн гэрт бус хамаатан садан, найз нөхдийнхөө гэрт амьдарч байгаа эсвэл шорон болон сэтгэцийн эмнэлэг мэтийн байгууламжид хоригдож байгаа хүнийг оруулдаггүй ажээ. Энэ нь бас тухайн тодорхойлолтын сул талыг харуулдаг.²

Хөгжингүй орнуудад өөрийн байртай эсвэл байранд байгаа л бол түүнийг орон гэртэй гэж үздэггүй байна. Орон гэргүй гэсэн тодорхойлолтод нийгмээс тусгаарлагдсан байдал, орон байрны шаардлага хангах эсэх ялгаварлан гадуурхалт зэрэг ойлголтуудыг багтаадаг.

БНСУ-д орон гэргүй хүн гэхээсээ илүү "тэнэмэл хүн"-ий тухай тодорхойлолтыг албан ёсоор хэрэглэж ирсэн байдаг. 1987 онд Эрүүл мэнд, нийгмийн яамнаас тэнэмэл хүний эсрэг арга хэмжээг зохион байгуулан шинэ заавар зөвлөмжийг гаргасан байна. Тус журмын 523 дугаар хэсэгт заасан тэнэмэл хүний тухай тодорхойлолтыг авч үзвэл "тодорхой оршин суух газаргүй юм уу түшиж тулах, харж хандах хүнгүй болон хамаатан садан байлаа ч гэр

¹ ХХНХЯ-ны сайдын 2012 оны А/51 тоот тушаал

² АНУ-ын конгресс, 1987

бүлийнхнээрээ хамгаалуулахыг хүсдэггүй хүн бөгөөд гудамжинд тэнүүчилж иргэдэд аюул бэрхшээл болон зэвүүцэл төрүүлэх зэргээр эрүүл нийгмийн хэв журмыг сахихад хүндрэл учруулах төдийгүй биеийн болоод сэтгэцийн эрүүл мэндээс болоод сэтгэн бодох болон ажиллах чадвар дутагдсан сэтгэцийн өвчтөн, архинд донтогч, гуйлгачин, гуйлга гуйдаг хүүхэд, 18 хүрээгүй тэнэмэл хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн" гэж тодорхойлсон байна. Солонгосын хот судлалын газраас орон гэргүй хүн гэдэг нэр томьёоны оронд "оршин суух хаяггүй этгээд" гэсэн нэр томьёог хэрэглэн тэднийг "оршин суух газаргүй хэрэн хэсэж явдаг оршин суух хаяггүй этгээд эсвэл тогтсон орон байртай болж чадаагүй хүмүүс гэж тодорхойлон ихэвчлэн орон байрны асуудлаас үүдэн зовлон үзэж байгаа хүн гэсэн утгыг товойлгон гаргаж өгсөн байна.

БНСУ-ын эдийн засгийн их хямралын үед буюу 1998 онд олон тооны орон гэргүй хүмүүс ихээр гарч ирэхэд орон гэргүй хүмүүсийн тухай сөрөг хандлагаас ангижруулахын тулд тэднийг хувь хүний алдаа дутагдлаасаа илүүтэй валютын хямралаас шалтгаалсан олон тооны ажилгүйдлийн хохирогч гэсэн утгаар "ажилгүй орон гэргүй хүмүүс" гэсэн ухагдахууныг хэрэглэх болжээ.¹

Үндсэн хэсэг

Орон гэргүй иргэдэд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх 40 гаруй загвар байдаг ч үйлчилгээний чиг баримжаа, агуулгаар нь нэгтгээд үндсэн гурван загвар болгож ашиглаж байна.²

1. Сэтгэл зүйн чиг баримжаат загвар: Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай орон гэргүй иргэдэд зориулагдсан. Эхний ээлжид эрүүл мэндийг нь гэсэн агуулгатай. Эмч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдээс бүрдсэн баг ажилладаг.

2. Социологийн чиг баримжаат загвар: Үндсэн орон сууц бөгөөд үүнийгээ эрүүл, хөгжлийн бэрхшээл, сэтгэл зүйн зөвлөгөө, чөлөөт цаг, хөдөлмөр эрхлэлт зэрэг бусад үйлчилгээтэйгээ зэрэгцүүлж явуулна. Орон гэргүй иргэдийг тухайн орон нутагт нь амьдруулах зорилготой.

3. Сэтгэл зүй- Социологийн чиг баримжаат загвар: Дээрх хоёр загварыг нийлүүлсэн төрөл бөгөөд хүмүүсийг орон гэргүй болохоос урьдчилан сэргийлэх, стрессээс гарах арга замд суралцуулах замаар бусад нийгмийн үйлчилгээг хамтарч хэрэгжүүлэх.

Хөгжингүй болон хөгжиж буй улсуудад аль алинд нь сэтгэлзүй-нийгмийн загварыг "Эхлээд орон байр" гэдэг хөтөлбөртэй хослуулан хэрэглэх нь донтолтын асуудалтай орон гэргүй, тэнэмэл иргэдийг сэргээн засах хамгийн үр дүнтэй арга

¹ МУИС "Нийгмийн ажил" сурах бичиг 2023 он 337 тал

² МУИС "Нийгмийн ажил" сурах бичиг 2023 он 337 тал

болох нь судалгаагаар тогтоосон. Дийлэнх улс орнуудад хэрэгжүүлдэг орон гэргүй иргэдэд чиглэсэн хөтөлбөрүүд:

1. Түр хугацааны дэмжих үйлчилгээний хөтөлбөр:

Яаралтай түр хоноглох байрны хөтөлбөр нь: түрүүлж ирсэнд нь гэсэн зарчмаар үйлчлүүлэгч нарт түр хугацаанд амьдрах орон байраар хангадаг. Энэ нь яаралтай, онцгой үед түр хугацааны хоноглох байр болгон ашигладаг нийтийн өмчийн байранд 1-3 өдөр амьдрах бололцоо олгодог. Ихэвчлэн шашны цуглаан, орон нутгийн иргэдийн хурал зэрэг өөр зорилгод ашигладаг энэхүү байрыг хэт хүйтний үед түр хоноглох байр хэлбэрээр ашиглаж болно.

Аюулгүй хоргодох байр нь: гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, гэрээсээ дайжсан, эцэг эхдээ хаягдсан хүүхдүүдэд чухал юм. Эдгээр хоргодох байр нь хүн амын тэдгээр бүлгүүдэд аюулгүй газар болдог.

Аутрич үйлчилгээ хөтөлбөр нь: орон гэргүй үйлчлүүлэгчид дээр очиж хоол хүнс, хөнжил гудас, ариун цэврийн хэрэгсэл болон бусад хэрэгцээтэй зүйлсээр үйлчилнэ. Энэ үйл ажиллагаа нь гудамж, гүүрэн доор, цэцэрлэгт хүрээлэн зэрэг янз бүрийн орчинд явагдана.

Халуун хоол хөтөлбөр нь: бэлэн боловсруулсан өглөө, өдөр, оройн хоолоор үйлчилнэ. Энэ нь хоолны цэгүүд, хайрцаг болон торонд хийж бэлтгэсэн өдрийн хоол, иргэд зориулсан хоолны ширээ бэлтгэх зэргээр явагдаж болно. Энэ хөтөлбөрүүд нь иргэд тухлан сууж хооллох байртай байж болно. Ийм үйлчилгээг ихэвчлэн шашны байгууллагууд болон бусад иргэдийн бүлгүүд тухайн газрын орчимд амьдардаг орон гэргүй, тэнэмэл иргэдэд үзүүлдэг.

Зөөврийн хүнсний хөтөлбөр нь: орон гэргүй, тэнэмэл иргэдэд хоол хүнс тараах зорилгоор тодорхой гудамж талбайд очиж үйлчилнэ. Хүмүүст заримдаа хоргодох байр олддог боловч янз бүрийн шалтгааны улмаас хоол хүнсгүй байх нь олон.

2. Эрүүл мэндийн хөтөлбөрүүд:

Архи, хар тамхины хөтөлбөр нь: орон гэргүй, тэнэмэл иргэдийн архи, мансууруулах бодисын хэрэглээ, донтолтыг бууруулах зорилготой үйлчилгээнүүд болно. Үүнд хордлого тайлах үйлчилгээ, архинаас гаргах эмчилгээ, сэргээн засах хөтөлбөр, зөвлөгөө, эмчилгээ, урьдчилан сэргийлэх, боловсролын үйлчилгээ багтана.

Биеийн эрүүл мэндийн хөтөлбөр нь: орон гэргүй, тэнэмэл иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлнэ. Үүнд эрүүл мэндийн үзлэг, халдваргүйжүүлэлт, хүнд өвчний үеийн эмчилгээ болон бусад эрүүл мэндийн үйлчилгээ орно. Ийм үйлчилгээ нь эрүүл мэндийн баг хоргодох байр, хоолны цэг, орон гэргүй, тэнэмэл иргэд тогтмол цугладаг газруудад очиж үйлчлэх байдлаар явагдах хэрэгтэй.

Сэтгэцийн эрүүл мэндийн хөтөлбөр нь: орон гэргүй үйлчлүүлэгч нарт сэтгэцийн болон сэтгэл зүйн эрүүл мэндээ сайжруулахад нь туслах үйлчилгээ юм. Кейс менежмент, хамт олны харилцаа, хямралын үед туслах, эмчлэх, зөвлөгөө, сэтгэцийн эмчилгээ, эмгэг зүйн үйлчилгээ, сэтгэцийн эмчилгээний хяналт зэрэг үйлчилгээ байж болно.

Бэлгийн замын /ДОХ/ халдварт өвчний эсрэг хөтөлбөр нь: бэлгийн замын халдварт өвчинтэй болон ДОХ-ын халдвар авах эрсдэл бүхий орон гэргүй, тэнэмэл иргэдэд зориулсан үйлчилгээ. Энэ үйлчилгээ нь эрүүл мэндийн үзлэг, өдрийн сувилгаа, хоол тэжээлийн үйлчилгээ, эм тариа, шаардлагатай үед эрчимт эмчилгээ, сэтгэцийн эрүүл мэнд, мансууруулах бодисын хэрэглээний эсрэг үйлчилгээ, үйлчилгээний талаарх лавлагаа мэдээлэл, ДОХ-оос урьдчилан сэргийлэх, түүний тухай боловсрол олгох зэргийг багтаана.

3. Урт хугацааны орон сууцжуулах хөтөлбөр:

Байнгын орон сууцны хөтөлбөр нь: орон гэргүй байсан хуучин үйлчлүүлэгч нарт урт хугацааны дэмжлэг үзүүлнэ. Энэ нь түрээсийн байранд амьдарч буй гэр бүлүүдэд тэр байрандаа цааш үргэлжлүүлэн амьдрах боломж олгож, шаардлага хангахгүй орчинд амьдрах байдлаас сэргийлэх юм.

Эрхийн бичиг өгөх үйлчилгээ нь: орон гэргүй, тэнэмэл иргэд шаардлага хангасан зочид буудалд тодорхой хугацаанд байх болон хүүхдийн асрамжийн газрыг төгссөн залуучуудад тодорхой хугацаанд амьдарч болох эрхийн бичиг буюу тасалбар олгоно. Энэ эрхийн бичгээр орон гэргүй, тэнэмэл иргэд түр амьдарч болох зочид буудал, асрамжийн газар зэрэг газраар үйлчилнэ. Энэ үйлчилгээ хүүхэдтэй эмэгтэйчүүдэд маш чухал.

Урт хугацааны хоноглох байр болон сэргээн засах хөтөлбөр: олон талт, цогц хэрэгцээ бүхий урт хугацаанд орон гэргүй байсан иргэдэд орон байр болон эмчилгээг санал болгодог. Энэ нь иргэдийг орон нутгийн иргэд дунд идээшүүлэх зорилготой эрчимтэй кейс менежмент болон олон талт үйлчилгээгээр хэрэгждэг.

4. Бусад хөтөлбөрүүд:

Тээврийн хэрэгслээр үйлчлүүлэх карт нь: эмчилгээний хөтөлбөр, сургалт, ажил хайх зэрэг тохиолдолд тээврийн хэрэгслээр үйлчлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Тусгай мини автобус: эрчимтэй кейс менежментийн хөтөлбөрт хамрагдсан иргэд болон тодорхой орон нутагт суурьшиж буй орон гэргүй, тэнэмэл иргэдэд тогтсон цагаар үйлчлэх орон нутгийн тээврийн үйлчилгээ юм. Үүний зардлыг орон гэргүй, тэнэмэл иргэдийн нийгмийн халамжийн төлбөрөөс гаргах боломжтой.

Орон гэргүй иргэдэд зориулсан ажлын ур чадвар олгох сургалт нь орон гэргүй, тэнэмэл иргэдэд ажлын ур чадвар олгоно. Ажил эрхлэх үед гарах асуудал, сорилтыг даван туулах арга замыг заана. Ийм хөтөлбөрүүд нь өмнө орон гэргүй,

архичин байсан иргэдэд тусгай сургалтын хөтөлбөрөөр дэмжлэг үзүүлэх ажил олгогч нарт татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх явдлыг багтааж болно.

Адвокаси үйлчилгээ нь орон гэргүйдлийг бууруулах, орон гэргүй, тэнэмэл иргэд болон бусад эмзэг бүлгийн иргэдэд туслахад шаардлагатай бүтцийн өөрчлөлт хийх талаар орон сууцны компаниуд ажил олгогч нар, хууль хэрэгжүүлэх байгууллага, улс төрчид, бизнес эрхлэгч нарт нөлөөлнө.

Орон гэргүй иргэдэд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх урт болон богино хугацааны зорилт гэж байдаг. Үйлчилгээний урт хугацааны зорилт нь:

1. Яаралтай түр хоноглуулах, хоолоор хангах үйлчилгээнд холбох
2. Түр хугацааны үйлчилгээнээс удаан хугацааны тогтвортой үйлчилгээнд шилжүүлэх
3. Эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамруулах
4. Архи, мансууруулах бодисын хамаарал, сэтгэцийн эрүүл мэндийн нэмэлт үйлчилгээ авах хэрэгцээг байгаа эсэхийг үнэлэх
5. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд холбон зуучлах

Богино хугацааны зорилт, холбогдох интервенц нь дараах агуулгатай байна. Үүнд:

1. Орон гэргүйдлээс үүссэн хямралыг тогтворжуулах
2. Орон гэргүй болсон шалтгааныг тодруулах
3. Байнгын орон гэртэй болоход учирч байгаа саад бэрхшээлийг тогтоох

Орон гэргүйдлийг багасгах, урьдчилан сэргийлэхэд урт хугацаатай, тогтвортой, санхүүжилт их шаардагддаг үйлчилгээ хэрэгтэй байдаг тул төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд, олон нийтийг татан оролцуулах нь илүү үр дүнтэй байдаг.

Орон гэргүй иргэдэд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний эрх зүйн орчин

Монгол улсын хувьд орон гэргүй иргэдийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний эрх зүйн орчин 2002 оноос эхлэн бий болсон. Тухайлбал 2002 онд Засгийн газрын 248 тоот тогтоол гарч "Орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэдийн талаар авах арга хэмжээний тухай журмыг баталсан. Үүний дараа 2008 онд НХХЯ-ны сайдын 08/141 тоот тушаалаар дээрх журмын хэрэгжилтийг нарийвчлан заасан. 2010 онд Сангийн сайд, НХХ-ийн сайдын хамтарсан 99-р тушаал гарч тус журамд нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэ нэмэлт өөрчлөлт нь эмзэг бүлгийн өрхөд хүнс, хоол тэжээлийн талон олгох журамтай холбоотой байсан.

2012 оны 7 сард батлагдсан "Нийгмийн халамжийн хууль"-ийн шинэчилсэн найруулгад орон гэргүй иргэдийг халамжийн зорилтот бүлэгт

оруулснаар хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс "Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэнд үзүүлэх халамжийн үйлчилгээний журам, үйлчилгээний чанарт тавиглах шалгуур батлах тухай" Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам (ХАХНХ)-ын сайдын 2012 оны 10-р сарын 29-ний өдрийн А151 тоот тушаал гарч орон гэргүй иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээг хүргэх, түүний чанарт тавих шалгуурыг тодорхойлж өгсөн. 2014 онд нийслэлийн засаг даргын А\164 тоот захирамж гарч орон гэргүй иргэдийг нийгэмшүүлэх зөвлөл байгуулагдсан.

Эдгээр журам, засгийн газрын тогтоол, нийгмийн халамжийн хууль зэрэг эрх зүйн актуудад үндэслэн одоогийн байдлаар манай улсын хувьд орон гэргүй иргэдэд дараах үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:

1. Орон гэргүй, тэнэмэл иргэдэд зориулсан түр хоноглох байраар хангах:

Нийслэлийн засаг даргын дэргэдэх "Амьдрах ухаан" сургалт, үйлдвэрлэлийн тусгай төв өөрийн хүчин чадлын дагуу 150 хүртэлх иргэнийг хүлээн авч байршуулах, халуун хоол, эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн ажлын чиглэлээр мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байна. Энэ нь орон гэргүй иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий төрийн байгууллага юм. Тус байгууллага 2018 оноос "Нийгмийн хамгааллын тусгай төв" нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

2. Хүүхэд хамгаалах төв: Хөдөлмөр эрхэлдэг, орон гэргүй, хүүхдүүдэд чиглэгдсэн ойролцоо үйл ажиллагаа явуулдаг 31 төвүүд улсын хэмжээнд байна. Эдгээрээс 24 нь олон улсын ТББ-аас ажиллуулж байгаа ба Засгийн газрын бус санхүүжүүлэлттэй байна. Эдгээр төвүүдэд хүүхэд хамгааллын чиглэлээр бэлтгэгдсэн, мэргэжлийн боловсон хүчин дутмаг байдаг. Стандартад багш хүүхдийн харьцаа 1:8 гэж заасан байгаа боловч боловсон хүчний хомсдолтойгоос 1:25 харьцаатай байна. Энэ байдал нь хүүхэд бүртэй тулж ажиллах, сургалт, хүмүүжил, нийгэмшлийн үйл ажиллагаа явуулахад ихээхэн хүндрэлтэй байдаг.

3. Халуун хоол, цай хөтөлбөр: Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр нийгмийн эмзэг бүлгийнхэнд хоол болон хүнсний тусламж үзүүлэх дэд хөтөлбөрийн дор халуун хоол, асрах байр болон нөхөн сэргээх хөтөлбөр нь 2011 оны 5 сараас НХХЯ-аар дамжин хэрэгжсэн. 2011 онд хэрэгжиж эхлэхдээ нэг өдөрт, нэг хүний халуун хоол 2000 төгрөг, байр хоногийн 2500 төгрөг байхаар зөвшөөрөгдсөн. 2014 оны 3 сард гарсан НЗД-ын захирамжийн дагуу нэг өдөрт, нэг хүний хоолонд 3500, байранд 4000, ариун цэврийн зардалд 500, эрүүл мэндийн үйлчилгээнд 500 төгрөгийг тус тус төсөвлөн ТББ-уудыг тендерт оролцуулж дөрвөн ТББ энэхүү эрхийг аваад нийт 163 сая төгрөгийн санхүүжилт хийгджээ.

4. Орон гэргүй иргэд ба зорилтот бүлэгт зориулсан "Энэрэл эмнэлэг": Энэхүү эмнэлэг нь эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах боломжгүй орон гэргүйчүүдэд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх зорилгоор Францын донор

байгууллагын санхүүжилтээр 1997 онд байгуулагджээ. Мөн цагаас хойш тус эмнэлэг нь дүүргийн хэмжээний эмнэлэг болтлоо хүчин чадал нь нэмэгдэж орон гэргүй мөн ядуу, эмзэг бүлгийн хүмүүст ямар нэгэн харьяалал, эрүүл мэндийн даатгал шаардахгүйгээр эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсээр байна.

5. Цагдаа болоод хуулийн үйлчилгээ: Орон гэргүй, тэнэмэл амьдралтай хүмүүсийг хаяг тогтоох, түр хоноглох байруудад хүргэж өгөх, архи их хэмжээгээр хэрэглэсэн хүмүүсийг эрүүлжүүлэх, осгох, бэртэж, гэмтэхээс урьдчилан сэргийлэх зэргээр ТББ- уудтай хамтран ажиллаж байна.

Нийслэлийн цагдаагийн газар холбогдох байгууллагуудтай хамтран орон гэргүй хүмүүсийг албан ёсоор тоолсон ба 1645 хүн нийслэл хотод байна гэж тоолсон бол 2024 оны байдлаар улсын хэмжээнд 2000 орчим хүн орон гэргүй байна гэдэг статистик байна. Улсын 3.5 сая хүн амтай харьцуулахад энэ статистик өндөр тоо юм. Өнөөдөр 125 сая хүн амтай Япон улсад 4000 хүн орон гэргүй байна. Азийн орнуудаас БНСУ орон гэргүй иргэдэд дэмжлэг үзүүлэх хуулийг 2002 онд баталж, хэрэгжүүлээд явж байна. Байр сууцаар хангасан, эрүүл мэнд, боловсрол, ажлын байраар дэмжлэг үзүүлдэг байгууллагууд байдаг.

Манай орон сүүлийн найман жилийн хугацаанд давхардсан тоогоор нийт 3014 орон гэргүй иргэнийг нийгмийн хамгааллын тусгай төвд байрлуулан зохих үйлчилгээнд хамруулж, 634 иргэнийн бичиг баримтжуулж, 1000 иргэнийг ажлын байранд зуучилж, 251 иргэнийг бие даасан амьдралд шилжүүлэн ажилласан. Гэтэл энэ хугацаанд 1686 иргэн орон гэргүй болж, шинээр бүртгэгдсэн, мөн орон гэргүй, тэнэмэл иргэд улсын тоо бүртгэлд бүртгүүлсэн хэдий ч бичиг баримтгүй учраас төрийн үйлчилгээ авч чаддаггүй мөн жилд 3-5 орон гэргүй хүнийг ахмадын асрамжийн төв рүү шилжүүлдэг байна.¹

Орон гэргүй болсон шалтгааныг урт хугацаанд нь ажиглаж, судалсан олон судалгаа бий. Тэгш бус байдал, ажилгүйдэл, ядуурал зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна. Түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэл, архины хамаарал зэрэг шалтгааныг ч судалсан олон улсын судалгаанууд байдаг. Монгол Улсад ч дээрх шалтгаан мөн адил илэрч буй. Гэрээсээ дайжсан, орон гэргүй байгаа шалтгааныг хэд хэдэн сонирхолтой хүчин зүйлтэй холбож авч үзэж байна.

Хүүхэд ахуй насандаа эцэг эх, багш, ахмад настан болон бусад том хүний тавьсан шаардлагыг дагадаггүй, хэтэрхий өөрийнхөөрөө өсөх тохиолдол ч үүнд хамаарч байна. Өөрөөр хэлбэл бага байхаасаа л томчуудын үгийг хүлээн авахгүй, шаардлагыг нь дагадаггүй, эсэргүүцдэг зан үйл нь ирээдүйд энэ нөхцөл байдал руу түлхдэг нэг хүчин зүйл юм байна. Үүнийг эрх мэдэлтнийг эсэргүүцэх


¹ <https://news.mn/>

зан үйлтэй холбоотой байж болзошгүй гэж олон улсад онцолж загварчилсан байдаг. Гэхдээ энэ бол орон гэргүй болох суурь шалтгаан биш.


Гэр бүлийн хүчирхийлэл, салалт, архидалтаас гадна Монголын онцлогтой холбоотой ямар нөлөөлөгч хувьсагч байна вэ гэдгийг давхар судалхад гэр бүлийн хүрээндээ тухайн хүүхэд хэт их хайр халамжид өссөн. Улмаар нас биед хүрсэн хойноо амьдралын саад бэрхшээлийг даван туулах чадваргүй болдогтой холбоотой байж болзошгүй нэгэн онцлог байдал судалгаагаар илрүүлсэн. Гэвч "Одоо орон гэргүй тэнүүчилж амьдарч байгаа нь бараг төсөөлшгүй зүйл" гэж хэлж байгаа тохиолдол ч гарсан. Монголчууд айлын ганц хүүхэд эсвэл отгон хүүхэд гэж хайрлаж, хамгаалах хандлагатай байдаг.

Улсын хэмжээнд орон гэргүй амьдарч байгаа иргэдийн (судалгаанд 405 иргэн хамрагдсан) 53.3 хувь нь ид хөдөлмөрийн насны буюу 25-49 насны иргэд байгаа нь анхаарал татаж байна.

Хаана хоноглож байгааг нь ялгаж харвал Өвлийн арваннэгдүгээр сараас гурван сарын хооронд түр хоноглох байруудад, дулаан улиралд гудамж, зуслангийн талбай зэрэг газруудад очиж хоноглодог байна. Харин хүйсээр нь ангилан авч үзвэл 87 хувь нь эрэгтэй, 13 хувь нь эмэгтэй байна. Өөрөөр хэлбэл орон гэргүй найман хүн тутмын нэг нь эмэгтэй, долоо нь эрчүүд байна. Насаар нь ангилбал хамгийн залуу нь 22 настай. Харин хамгийн ахмад настай хүн нь 78 настай иргэн байна.



Судалгаанд хамрагдсан иргэдийн боловсролын үзүүлэлтүүд улсын дунджаас доогуур байна. Тодруулбал:



Дээд боловсролтой гэж хариулсан хүмүүсийн мэргэжлийн чиглэл ямар байгааг ерөнхийлөн харвал цэрэг армийн эрчүүд, уул уурхайн салбар болон урлагийн салбарын хүмүүс арай илүү байсан үзүүлэлт харагдав.¹

Орон гэргүй иргэдийн 90 хувь нь архины хамааралтай байдаг. Тэдний архинд донтох болсон гол шалтгаануудын нэг нь гэр бүл салалт юм. Гэр бүлээсээ салсан ганцаардсан байдлаа даван туулж, сэтгэлээ тайтгаруулахын тулд архи хэрэглэж эхэлдэг. Архи уугаад ирэхээр эрүүл мэндээс гадна сэтгэл зүйн давхар гэмтдэг. Өөрийгөө бодитоор үнэлэхээ болих, хариуцлага хүлээх чадваргүй болох, өөрийгөө батлан харуулах хүсэл бий болох зан араншин тод илэрдэг. Нөгөө талаас эдгээр иргэд дотогшоо чиглэсэн сэтгэл зүйтэй, нээлттэй бус хүмүүс байдаг. Тиймээс өөрийн жаргал, зовлонгоо бусадтай бус архитай хуваалцдаг гэсэн үг. Энэ үед орон гэргүй хүмүүст архины хордлого тайлах эмчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх шаардлагатай байгааг 2021-2022 онд 500 гаруй иргэнээс авсан судалгаагаар тодорхойлжээ.²

Монгол Улсын хувьд 5-6 төрийн бус байгууллагын байр, нэг улсын байранд байршуулж, үйлчилгээ үзүүлж байна. Эдгээр төв нь орон гэргүй иргэдийн зөвхөн 20 хувьд нь үйлчилдэг учраас орон байр хүртээмжгүй байдаг.

Хорих ангиас сууллагдах дөхсөн хүлээн авах гэр бүлгүй, орон гэргүй хоригдолд үзүүлж буй нийгмийн ажлын үйлчилгээ

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/167, А/233 дугаар тушаалаар батлагдсан “Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хөтөлбөрийг хэрэгжүүлэгч бусад байгууллагатай хамтран ажилладаг.

“Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийн хүрээнд ШШГЕГ-ын харьяа 7 хорих анги нөөц боломж, төрийн бус байгууллагын санхүүжилтээр “Суллагдахад бэлтгэх байр”-ыг, 2 хорих анги “Суллагдахад бэлтгэх өрөө”-г тохижуулж, хоригдолд нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж байна.

“Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийн дагуу хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хэлтэс нь бие дааж болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран ажиллах гэрээ бүхий төрийн бус байгууллагатай хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг таниулан ойлгуулах, хууль, эрх зүйн мэдлэг, олгох, хувь хүний хөгжлийг хангах амьдрах ухааны, сэтгэл зүй харилцааны чиглэлээр сургалт, нөлөөллийн арга зохион байгуулж ажилласан ба сургалтад нийт давхардсан тоогоор 2968

¹ “Орон гэргүй иргэдийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал” судалгааны тайлан УБ 2023 он ШУТИС-ийн БУХС-ийн багш, доктор, дэд профессор С.Туяа

² НЗДТГ харьяа Нийгмийн хамгааллын тусгай төвөөс хийсэн судалгааны үр дүн 2023 он

хоригдлыг хамруулсан байна.¹

“Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.1.3 дахь хэсэгт “Суллагдсаны дараа оршин суух газрын хаяг, байршлыг тодорхой болгож, нийгэмд амьдрах, хөдөлмөр эрхлэх чадварт үнэлгээ хийх” гэсний дагуу хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хэлтэс нь 593 хоригдолд үнэлгээ хийж хэрэгцээг тодорхойлон хэрэгцээнд нь тохирсон нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлж, “Тэр бүлийн боловсрол”, “Амьдрах ухаан”, “Иргэний боловсрол”, “Архи, согтууруулах ундааны хор уршиг”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль” “Харилцаа хандлага”, “Тэр бүлийн харилцаа, гишүүдийн үүрэг”, “Стресс бухимдал”, “Сэтгэл зүй”, “Зан чанарыг өөрчлөх”, “Донтолтын эсрэг”, “Сөрөг бодол, зан үйлээс татгалзах нь”, “Хувь хүний хөгжил” зэрэг сургалтыг зохион байгуулсан байна.

“Суллагдахын өмнөх байр”-нд өдөрт 4-12 цагийн хугацаагаар байрлуулан гэр бүлд нь эргэн нэгтгэх, суллагдсаны дараа гэр бүл, найз нөхдийн харилцаа хандлагын талаар сургалт, зөвлөгөөг ярилцлагын хэлбэрээр зохион байгуулан ажилладаг байна. Мөн 323 хоригдлын ар гэрийнхэнтэй утсаар холбогдож, эргэлт уулзалтаар ирсэн үед нь уулзаж тухайн хоригдлын талаар харилцан мэдээлэл солилцох, суллагдсаны дараа хүлээн авах орчин, ар гэрийн харилцаа холбоог судлах ажлуудыг зохион байгуулж, тохирох үйлчилгээ, мэдээ мэдээллийг өгсөн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, байгууллага нь Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран 2023 онд давхардсан тоогоор 1725 хоригдлыг бичиг баримтжуулахаар харьяа улсын бүртгэлийн хэлтэст холбогдох бичиг баримтыг хүргүүлж, иргэний бүртгэлийн байгууллага болон хоригдлын ар гэртэй хамтран ажиллаж 689 хоригдлыг бичиг баримтжуулсан байна. Тэдгээр хоригдлуудын хувьд 37 хоригдол оршин суух тодорхой хаяггүй, 7 хоригдол овог, нэр, регистрийн дугаарын мэдээлэл зөрүүтэй, 63 хоригдол улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсийг төлөх боломжгүй зэрэг шалтгааны улмаас иргэний бичиг баримтжуулах боломжгүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, “Үлэмж илүү”, “SAMUSHIL” хөдөлмөр зуучлалын фирмтэй хамтран “Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/167, А/233 дугаар тушаалаар батлагдсан “Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийн 2.1.4 дэх заалтын хэрэгжилтийг хангах, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, хорих ял эдэлж буй хоригдлыг зах зээлийн эрэлтэд сургалтыг хослуулан сурган дадлагажуулах, тэдний мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, хорих ангиас суллагдсан иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих,

¹ ШШГЕГ-ын 2023 оны үйл ажиллагааны тайлан, мэдээ

ажлын байранд зуучлах” зорилгоор “Санамж бичиг”-ийг байгуулж, сургалт үйл ажиллагааг зохион байгуулан ажилладаг.

2023 оны байдлаар хорих ангид ял эдэлж байгаа суллагдах хугацаа дөхсөн нийт 254 иргэнийг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажлын байранд зуучлан нийгэмд бие даан амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажилласан байна.¹

Хоригдлуудын хууль, эрх зүй, нийгмийн баталгааг хангах тэдний урьд тогтоолгосон тэтгэвэр, тэтгэмжийг үргэлжлүүлэн авах хуульд заасан болзол шаардлагыг хангасан тохиолдолд хуулиар тогтоосон тэтгэвэр, тэтгэмжийг олгуулах ажлыг зохион байгуулж нийт 103 хоригдолд урьд авч байсан өндөр насны тэтгэвэр, 30 хоригдолд “Насны хишиг”-ийг тус тус олгуулсан байна.

Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хоригдлыг хамруулах ажлыг 2020 оноос зохион байгуулж байгаа бөгөөд 2023 онд 53 хоригдол нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамрагдаж, нийт 8,240,800 төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлсэн байна.

Түүнчлэн хорих ангиас суллагдсан ар гэр, оршин суух хаяггүй, хөгжлийн бэрхшээлтэй 2 хоригдлыг Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Нийгмийн хамгааллын тусгай төвд шилжүүлэн өгсөн байна.

ДҮГНЭЛТ

Орон гэргүйдлийг нэг мөр тодорхойлоход хүндрэлтэй бөгөөд тухайн улс орны эдийн засаг, нийгмийн хөгжил, соёл уламжлалаас хамаарч өөр өөр байдлаар илэрдэг тул улс үндэстэн бүр өөрийн онцлогт тохируулан шалгуур боловсруулах, тодорхойлох шаардлагатай.

Орон гэргүй болж болзошгүй, зориулалтын бус орон сууцанд амьдарч байгаа иргэд гэж бий. Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал хямрахад л тухайн гэр бүл задарч, гишүүд нь орон гэргүй болох эрсдэлтэй. Тиймээс тэдэнд чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах нь зайлшгүй байна.

Орон гэргүйдэл нь нийгэм, эдийн засаг, гэр бүл, хувийн хүчин зүйлээс шалгаалдаг цогц шинжтэй нийгмийн асуудал учраас түүнд чиглэсэн үйлчилгээ нь урьдчилан сэргийлэх, эрт үеийн туслалцаа болон хямралаас сэргийлэх үйл ажиллагаа зэргийг багтаасан цогц байх шаардлагатай байна.

Монголын нөхцөлд орон гэргүйдлийн эсрэг үйлчилгээг архинд донтолтын хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх, эрт үеийн туслалцаа болон эмчилгээний талаарх мэдээлэл сурталчилгаатай хослуулах нь чухал. Төрийн зүгээс орон гэргүй иргэдэд үзүүлж байгаа нийгмийн халамж, үйлчилгээг хүн амын тодорхой

¹ ШШГЕГ-ын 2023 оны үйл ажиллагааны тайлан, мэдээ

бүлгүүдэд чиглэсэн, тэдэнд тохирсон үйлчилгээний хувилбараар дамжуулж хэрэгжүүлэх хэрэгцээтэй байна. Жишээ нь: орон гэргүй хүүхдүүдэд зориулсан үйлчилгээ нь орон гэргүй болох эрсдэлд орсон гэр бүлд чиглэсэн үйлчилгээнээс ялгаатай байх хэрэгтэй.

Хорих ангиас суллагдан гараад хүлээн авах хүнгүй, орон гэргүй хоригдлын судалгааг улирал тутамд гарган оршин суух орон нутгийн халамжийн байгууллагад хүргүүлж, асуудлыг шийдвэрлэж ажиллахад төрийн байгууллагуудын хамтрын ажиллагаа чухал байна.

Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжээс хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүнд олгохоор заасан ч хорих ангиа суллагдан иргэн харьяа дүүрэг, халамжийн байгууллагад хандан асуудлаа шийдвэрлүүлэхэд хүндрэлтэй байдаг асуудал байсаар байна.

САНАЛ

Орон гэргүй хүмүүсийн асуудал нь зөвхөн орон байргүй гэсэн асуудалд хандах хандлага бус ядуурлаас урган гарсан нийгмийн бүтэц зохион байгуулалтын асуудал учраас орон гэргүй хүмүүсийн хувь хүний гэр бүлийн болон нийгэм, сэтгэл зүйн байдлыг хүртэл багтаасан цогц ухагдахуунд суурилан орон гэргүй хүмүүс рүү чиглэсэн өргөн хүрээний нийгмийн хамгааллын бодлогыг бий болгох хэрэгтэй.

Халуун шөлөөр үйлчлэх, үнэгүй хоол хүнс тараах, ариун цэврийн хэрэгсэл, зөөврийн хоол хүнсний хөтөлбөр, явуулын эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг нь орон гэргүүдлийн асуудлыг шийдэхэд олон нийтийг өргөнөөр татан оролцуулах сайн аргууд учраас тэдгээрийг хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоонд түшиглэж нийгмийн бусад институцийг татан оролцуулах шаардлагатай.

Хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн орон гэргүй дахин нийгэмших шаардлагатай иргэдийг хүлээн авах тэдэнд дэмжлэг тусалцаа үзүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх

Аймаг, нийслэлийн засаг дарга, иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга нартай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хоригдлыг суллагдахад бэлтгэх “хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар тусгаж, төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, бодлогын нэгдмэл байдлыг хангах,

Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын төсөвт “хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардал болон “Суллагдахад бэлтгэх байр”-ыг

байгуулах төсвийг тусгах, бусад төсөл хөтөлбөр, зээл тусламжид хамруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах,

Хорих ангиас суллагдаад очих газаргүй орон гэргүй иргэдийг нийгэмд дасан зохицоход сайн дурын байгууллага, иргэдийг татан оролцуулах нь тухайн иргэн дахин гэмт хэрэг үйлдэх, бусад сөрөг үр дагавараас /архи мансууруулах бодист донтох гм/ урьдчилан сэргийлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

Эх сурвалж

Нийгмийн ажил. сурах бичиг. УБ., 2023.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэх гарын авлага. УБ., 2017.

Нийслэлийн засаг дарга Орон гэргүй иргэдэд нийгмийн үйлчилгээ үзүүлэх журам

Дэлхийн банк Монгол Улсын орон гэргүйдлийн нөхцөл байдал судалгааны тайлан. УБ., 2012.

Туяа, С. Орон гэргүй иргэдийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал. Судалгааны тайлан. УБ., 2023.

---o0o---